



НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 1/11

Улаанбаатар хот

Байгууллагын ёс зүйн дэд хороог
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 12 дугаар зүйлийн 12.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.4 дэх хэсэг, Ёс зүйн хорооны журмын 3 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн Хамт олны хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус төвийн Ёс зүйн дэд хорооны гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай. Үүнд

Дарга	Хуулийн зөвлөх	Г.Бат-Отгон
Нарин бичиг	Сэтгэл зүйч	Б.Буянсүрэн
	Ерөнхий нягтлан бодогч	Б.Энхдолгор
	Хөдөлмөр эрхлэлтийн ажилтан	Э.Эрдэнэмаа
	Нярав	Б.Отгонсайхан

2.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг үйл ажиллагаандаа баримталж ажиллахыг Ёс зүйн дэд хорооны гишүүдэд үүрэг болгосугай.

3.Ёс зүйн дэд хорооны гишүүнээр ажилласны урамшууллыг зохих журмын дагуу тооцож олгохыг Нягтлан бодогч (Б.Энхдолгор)-д зөвшөөрсүгэй.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/15 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ш.МӨНХЦЭЦЭГ